



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/314

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Барилгын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2 дах хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж буй “Ахмадын өргөөний барилга Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Баянзүрх сум”, “Нийтийн халуун усны барилга Алаг-Эрдэнэ, Баянзүрх сум” төсөл арга хэмжээний гүйцэтгэлд газар дээр нь хяналт, шалгалт хийж дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч -Б.Оюунтуяа (Аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүдэд: А.Догсмоо (Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, ахлах аудитор, санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч)

Д.Сандагдорж (Аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохион байгуулах мэргэжилтэн)

Б.Энхжаргал-(хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн )

Д.Мягмарсүрэн –(Барилга, техникийн хяналтын Улсын байцаагч)

Х.Даваасүрэн- ("Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Х.Буянтогтох (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, цаашид авах арга хэмжээний саналын төсөл боловсруулж, холбогдох дүгнэлт гарган танилцуулахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712010330